

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

*ХСИС-н Ахисан Шатны Боловсролын Сургуулийн
гэмт явдал судлалын магистрант цагдаагийн ахмад А.Алтансүх*

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд устаж үгүй болохгүй, аль ч нийгэмд байсаар ирсэн түүхтэй. Түүний гаралтыг зөнд нь орхих бус, харин түүнтэй тэмцэх, тэр дундаа урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулж явуулах нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлага болсоор байна.

Өнөөдөр дэлхий нийтийн цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй явуулахдаа иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний туслалцаа дэмжлэгэд түшиглэж явуулахын чухлыг хүлээн зөвшөөрч энэхүү чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал:

Түрк улс нь 80 сая хүн амтай, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын хувьд хүнд орон бөгөөд террорист халдлага, зохион байгууллалтай томоохон гэмт хэргүүд үйлдэгддэг. Тус улсын цагдаагийн байгууллага нь 200 гаруй мянган алба хаагчтай, нарийн бүтэц зохион байгуулалттай, цагдаа-иргэдийн харилцааг хөгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, тодорхой байгууллагуудтай хамтарч ажиллах, сургалт сурталчилгаа явуулах, судалгаа шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих бодлого баримталдаг байна. Тухайлбал:

- Цагдаа иргэдийн харилцааны чиглэлээр дагнасан үйл ажиллагаа явуулдаг нэгжийг Цагдаагийн байгууллагад ажиллуулдаг.
- Энэ чиглэлээр судалгааны ажлуудыг эрчимтэй явуулж, гарсан бүтээлийг хөхүүлэн дэмждэг
- Цагдаагийн байгууллагын бүх шатны сургалтын хөтөлбөрт “Цагдаа – Иргэдийн харилцаа” хичээл ордог
- Олон нийтийн мэдээллийн бүх хэрэгсэлтэй бэлэмжтой бүх арга, хэлбэрээр хамтарч ажилладаг
- Цагдаагийн байгууллага нь “Полис ФМ” буюу цагдаагийн богино долгионы радиог иргэдийн дунд давхар ажиллуулдаг гэх мэт олон талт зохион байгуулалтын арга хэмжээ авч, байнга боловсронгуй болгож байдаг байна.

Их Британи улсад 200 гаруй гишүүдтэй Их Британы Цагдаагийн байгууллагын дэргэд 1997 онд цагдаагийн байгууллагын олон нийтийн мэдээлэл сурталчилгааны холбоо ажилладаг.

Тус холбоо нь Цагдаагийн байгууллага олон нийтийн мэдээлэл сурталчилгааны харилцаа, үүнтэй холбогдох салбаруудын үйл ажиллагааны ач холбогдлыг нийтэд танин мэдүүлэх, хөгжүүлэх, олон нийтийн мэдээлэл сурталчилгааны харилцааны асуудлыг хариуцсан цагдаагийн алба хаагчдын үүргийг ойлгуулан сурталчилах, дэмжлэг үзүүлэх,

сургалт явуулах, заавар зөвлөмж өгөх, гишүүдийн хоорондын харилцааг хөгжүүлэн сүлжээ бий болгох, тэргүүн туршлагаасаа харилцан солилцох, мэргэжлийн хүмүүсийг сүүлийн үеийн шинэ нээлт, хөгжлийн талаар мэдээллээр хангах зорилготой.

Индонез улсын Цагдаагийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны гол цөмд нийгмийн түншлэл /харилцах/, үүссэн аливаа асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, удирдлагын арга зүйг өөрчлөх илүү анхаарал хандуулдаг байна.

Цагдаагийн байгууллагаас олон нийттэй хамтран ажилладаг хамгийн том хэлбэр нь Олон Нийт Цагдаагийн Хамтын Ажиллагааны нэг хэлбэр болох кобан систем юм.

Мөн 30 жилийн өмнөөсиргэдэд зөвлөлгөө өгөх хэсгийгажилуулан,тусгайхөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн.

Уг хөтөлбөрийн хүрээнд ард иргэдийг хүлээн авах,гомдлыг нь түргэн шуурхай шийдвэрлэх, насанд хүрээгүй хүүхдэд тусалцаа үзүүлэх, залуу үеийнхэнтэй түншлэлийн харилцаа тогтоох зэрэг хэлбэрийн ажилуудыг дэмжинэ зохион байгуулдаг байна.

Цагдаагийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн санаачлагаар тэдний аюулгүй байдлыг хангах постуудыг байгуулан тодорхой цэгт ажилладаг ба үйл ажиллагаанд нь цагдаагийн байгууллага зөвлөн тусалж мэргэжлийн удирдлагаар хангадаг бөгөөд далайн эрэг орчмоор пост гаргаж иргэдийг уснаас аврах, эрэг орчмоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эргүүл хийдэг байна.

Сингапур улсад манай улсын адилгэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн байгууллагад туслах зорилгоор Үндэсний зөвлөл ажилладаг байна.

Тус зөвлөл нь улсын хэмжээнд аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийт, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг зохицуулах, цагдаа, олон нийт, бизнесийн бүлэглэлүүдтэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд шинэ санаа санаачлагыг дэмжих замаар ажилладаг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах ажлыг дэлхийн олон улс орон янз бүрийн нэршил, хэлбэртэйгээр хэрэгжүүлж ирсэн бөгөөд зарим улс орнуудад “Хөршийн хяналт”-ын системийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар онцгойлон авч үзлээ.

Тухайлбал, АНУ, Англи, Швед улс орнуудад нэвтрүүлсэн “Хөршийн хяналт”-н хэлбэрээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд хэрэгждэг байна.

Хөршийн хяналтын систем нь анх Хойд Америкийн нутаг дэвсгэртнэвтэрсэн бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэргүүн туршлага шилдэг аргуудын нэг юм байна.1960-аад оны сүүлчээс гэмт хэргийн гаралт маш ихээр нэмэгдэж байсан учраас иргэд, оршин суугчдад түшиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэх шаардлагатай болж, Үндэсний шерифийн холбооноос 1972 онд иргэд, хууль сахиулах байгууллагын хоорондын уялдаа холбоог сайжруулах, тэдэнд туслах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр “Хөршийн хяналт” Үндэсний хөтөлбөрийгхэрэгжүүлж эхэлсэн байна.

2001 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн АНУ-д болсон террорист халдлагын хор уршгийн дараагаар аюулгүй байдлыг хангах үүсгэл санаачлагын байгууллагуудын үйл ажиллагаа нь урьд өмнө байгаагүйгээр эрчимжиж Хөршийн хяналт хөтөлбөр нь өргөжиж террорист халдлагаас сэрэмжлэх, байгалийн гамшигт үзэгдлийн бэлэн байдлыг хангах, яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон байна.

Швед улсад Хөршийн харуул хамгаалалтыг ажилуулдаг байна. Хөршийн харуул хамгаалалтыг Шведийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Үндэсний Зөвлөлөөс удирддаг.

Хөршийн харуул хамгаалалтын зорилго нь оршин суугчид өөрсдийн амьдарч буй орчинг хөгжүүлэхэд цагдаа, хотын захиргааны дэмжлэг туслалцаа авах хамтран ажиллахад орших ба гэмт хэргийг бууруулж, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх чадварлаг нөхөрлөлийн бүлэг, бусад оролцогч талуудтай хамтран ажиллах боломжийг олгож, хүмүүсийн хүссэн таатай амьдрах орчинг бүрдүүлэхэд чамгүй хувь нэмрээ оруулдаг ажээ.

Тухайн орчинд хөршийн харуул хамгаалалтын оролцоог дэмжих, сэргээх уг хамгаалалтын ажилтнуудаас сурталчилах томоохон хэмжээний урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулдаг байна.

Хөршийн харуул хамгаалалтын дүнд хяналтын түвшин дээшилж хүссэн зүйлээ хулгайлах боломжийг бууруулснаар хулгай, дээрмийн гэмт хэргүүд буурч хорлон болон хорлон сүйтгэх ажиллагаатай нэн тэргүүнд тэмцэх үр дүнтэй арга болсон гэж дүгнэдэг байна.

Англи улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд “Хөрш болон айл өрхийн хяналтын сүлжээ” гэсэн нэршилтэйгээр хөршийн холбоог үйл ажиллагаагаар дамжуулан иргэдийг татан оролцуулж байна. Уг холбоо нь үндсэн дүрэм нь 2009 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан дүрэмтэй байна. Хөршийн холбооны үндсэн зорилго нь:

1. Гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын нэгдлүүдийн үйл ажиллагаанд тулгуурласан аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих, дээрх чиглэлээр иргэдийн ухамсрыг дээшлүүлэх.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага болон бусад хамтран ажиллагч байгууллагуудад туслалцаа үзүүлэн, олон нийтийн оролцоог хангах.

Дэлхийн хоёрдугаар дайны үед Япон Улсын засгийн газраас хэмжиж өгсөн бараа материалыг хуваарилах, гаргасан бондыг тараах, гал түймэртэй тэмцэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон иргэний хамгааллын үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх үндэсний шашны хөдөлгөөнийг дэмжих, баримталж байгаа бодлогыг олон нийтэд түгээх, эх оронч үзлийг бий болгох, иргэдээ дайнд бэлтгэх, цэрэг таталт, цэргийн техник үйлчилгээны ажлыг зохион байгуулах арми болон төрийн байгууллагад туслах үүрэг хүлээсэн иргэдийн бүлэг хэсэг ажиллах үндэсний хөтөлбөр бөгөөд аюулгүй байдлыг хангах хамгийн бага, жижиг анхан шатны нэгж юм. Энэ нэгж нь 10-15 айл өрхийг нэг нэгж болгодог байжээ.

Япон Улс дахь хөршийн холбоонд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг хэлбэр нь Эдогийн¹ үеэс үүсэлтэй юм. Япон Улсын ерөнхий сайд байсан Фумимаро Коноёогийн харьяанд багтдаг Дотоод хэргийн яамны 1940 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар анх зохион байгуулалтанд орж байгуулагдаж байсан тухайн үйл ажиллагаанд оролцох нь хүн бүрийн үүрэг байжээ.

¹ Манай тооллын 1603-1868 оныг хүртэлхийг Япон улс нь гадаад улсаас хаалттай бодлого хэрэгжүүлж энэ үеийг Эдогийн эрин үе гэж тэмдэглсэн байдаг бөгөөд 1868 оноос Япон улс гадаад улсад нээлттэй бодлого хэрэгжүүлж нийгэм эдийн засгийн шинэчилсэн бодлог явуулж орчин үеийн Япон улсын эхлэл тавьсанаар Мэйжигийн эрин үе эхэлсэн гэж үздэг байна.

1947 онд Америкийн эрх мэдэлтнүүдийн нөлөөллөөр иргэн бүр заавал оролцох хөршийн холбооны хэлбэр татан буугдаж өнөөгийн нөхцөлд сайн дурын үүсгэл санаачлагын бие даасан холбоо болох *chonaikai* эсвэл *jichikai* гэсэн нэршилтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн жилүүдэд хүүхэд, залуучууд гэмт хэрэгт ихээр холбогдож байгаа нь эцэг эх, иргэд олон нийтийн анхаарах ёстой асуудлын нэг болж, тэдний идэвхитэй үйл ажиллагаа нэн тэргүүнд шаардагдаж байгаа талаар ²дурьдсан байна.

Өнөөдөр Улаанбаатар хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа нэг томоохон төсөлт ажил бол “Хөршийн хяналт” хөтөлбөр билээ.

Хөршийн хяналт нь манай улсад 1990 оноос өмнө “хөршийн холбоо” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэл нь харьцангуй хязгаарлагдмал шинжтэй байжээ.

Статистик мэдээнээс³ үзвэл, гэр, орон сууцанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн 50-60 хувийг иргэдийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30-40 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Ялангуяа гэр хороолол, орон сууцны орчимд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад иргэдийн үүрэг оролцоо чухал гэдэг нь гадаадын улс орнуудад хэрэгжиж байгаа “Хөршийн хяналт”-ын нэгдлүүдийн практик туршлагаас илхэн харагдаж байна.

Дээр дурьдсан орнуудын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан ажилд иргэд олон нийтийг оролцуулж байгааг дүгнэж үзэхэд өөрийн орны онцлогд тохирсон үр дүнтэй арга, хэлбэр ашиглаж иргэд, олон нийтийн оролцоонд түшиглэсэн бүтэц, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

Энэ бүхнээс үндэслэн дараах санлуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1.Индонез улсын зарим туршлагыг судлан, нэвтрүүлжиргэдийн санаачлагаар малын хулгайн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх малчин холбоо, байгалын баялагыг зүй бусаар ашиглах болон хулгайн анчдаас хамгаалах сайн дурын болон олон нийтийн цагдаагийн ажилтанг бий болгон байгал хамгаалагчтай хамтран ажилуулах.

2.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд туслахзорилгоорсайн дурын холбоо нэгжийг тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дэргэд байгуулах.

3.Цагдаагийн байгууллагын дэргэд цагдаагийн байгууллагын олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажилтануудын холбоо байгуулан ажиллаж иргэдийг оролцуулах.

4.Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа хөршийн хяналт хөтөлбөрийн нэр томъёог өөрчилж үйл ажиллагааг нь сайжруулж улсын хэмжээнд хэрэгжүүлэх.

²Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа.гарын авлага.УБ.,2010. 4 дэх тал

³ЦЕГ-н МСДШТөвөөс 2015 оны гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнээс хэсэгчилэн авав.